



# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль

*Эрүүл мэндийн газрын НЭМТ*



ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 01 сарын 12 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

## НИЙГАМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хүн амын эрүүл мэнд, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг таних, судлах, үнэлэх, хариу арга хэмжээг авах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.


#### 2 дугаар зүйл. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хууль тогтоомж

2.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Дархлаажуулалтын тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, Хүний дархлааг хамгаалах вирусын халвар, дархлааны өлдмөл хомсдолос сэргийлэх тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Хүнсний тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагах мөрдөнө.

#### 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

- 3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:
  - 3.1.1. "нийгмийн эрүүл мэнд" гэж хүн, байгаль, нийгмийн зохицог хангаснаар хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй амьдрах орчин бүрдүүлэх чиглэлээр хувь хүн, хамт олон, байгууллага, салбар хоорондын зохицуулалттай, судалгааны үр дүн, нотолгоонд суурилсан нийтээр хэрэгжүүлэх ноцол арга хэмжээг;
  - 3.1.2. "нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ" гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 13.2-т заасныг;
  - 3.1.3. "нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал" гэж хүний болон зоономын халдварт өвчний дэгдэлт, шалтгаан тодорхойгүй өвчлөл, өвчлөлийн шинэ тохиолдол, хийм, цэвэрлэлийн осол, хорлогод хүн ам өрсөн, эсхүл өртөх нөхцөл үүсснийг;
  - 3.1.4. "эрүүл мэндийг дэмжих" гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.19-д заасныг;
  - 3.1.5. "эрүүл мэндийг хамгаалах" гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.2-т заасныг;
  - 3.1.6. "гандлаг" гэж хүний эрүүл мэндэд үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийг ажиглах, судлах, мэдээ, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэх, мэдээлэх, холбогдох арга хэмжээг төлөвлөх үйл ажиллагааг;



Энэ хуулийн зорилт нь хүн амын эрүүл мэнд, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг таних, судлах, үнэлэх, хариу арга хэмжээг авах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ᠨᠢᠶᠦᠭᠡᠮᠢᠨᠢ ᠡᠷᠦᠭᠦᠯᠡᠮᠡᠨᠳᠢᠶᠢᠨ ᠲᠤᠰᠤᠯᠠᠮᠵᠢ ᠦᠶᠢᠯᠴᠢᠯᠭᠡᠭᠡᠨᠢ ᠲᠤᠬᠤᠢ



# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль

“Нийгмийн эрүүл мэнд” гэж хүн, байгаль, нийгмийн зохицлыг хангаснаар хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй амьдрах орчин бүрдүүлэх чиглэлээр хувь хүн, хамт олон, байгууллага, салбар хоорондын зохицуулалттай, судалгааны үр дүн, нотолгоонд суурилсан нийтээр хэрэгжүүлэх цогц арга хэмжээ гэж тодорхойлсон;





## Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, үйл ажиллагааны чиглэл

- 5.1.1.халдварт болон халдварт бус өвчний хяналт;
- 5.1.2.орчны эрүүл мэнд;
- 5.1.3.хөдөлмөрийн эрүүл мэнд;
- 5.1.4.хүнсний аюулгүй байдал, шим судлал;
- 5.1.5.нийгэм, сэтгэц-зан үйл;
- 5.1.6.нөхөн үржихүйн эрүүл мэнд;
- 5.1.7.нийгмийн эрүүл мэндийн лаборатори;
- 5.1.8.нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын хариу арга хэмжээ.



Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрлийг дараах чиглэл тус бүрээр үзүүлнэ:


5.10.1.тандах, судлах;

5.10.2.эрүүл мэндийг дэмжих, хамгаалах;

5.10.3.эрүүл мэндийн боловсрол олгох;

5.10.4.урьдчилан сэргийлэх, үнэлэх, хянах;

5.10.5.олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг хангах





# НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

11.1.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дараах байгууллага, нэгж, алба үзүүлнэ:

11.1.1.нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан үндэсний төв;

11.1.2.аймаг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв;

11.1.3.өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв;

11.1.4.эрүүл мэндийн байгууллагын нийгмийн эрүүл мэндийн нэгж, алба;

11.1.5.аж ахуйн нэгж, байгууллага

11.5.Энэ хуулийн 11.1.3-т заасан байгууллагын иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний **тэргүүлэх чиглэл нь** нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ байна.

11.6.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд халдварт болон халдварт бус өвчний асуудал хариуцсан **нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнийг ажиллуулна**



# Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх байгууллагын чиг үүрэг

12.2. Аймаг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.2.1. нийгмийн эрүүл мэндийн талаар баримтлах хөгжлийн бодлого, чиглэл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх асуудлаар эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

12.2.2. хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх орчны хүчин зүйлийг тогтоох, тандалт, судалгаа хийх, урьдчилан сэргийлэх, хянах, холбогдох арга хэмжээг нутаг дэвсгэрийн хэмжээнд төлөвлөн зохион байгуулах;

12.2.3. шуурхай удирдлагын нэгжтэй байх бөгөөд нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

12.2.4. халдварт болон халдварт бус өвчин, түүний эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийг зохион байгуулж, хэрэгжүүлэх;

12.2.5. хүнсний аюулгүй байдал, шим тэжээлийн зохистой байдал алдагдсанаас шалтгаалсан өвчлөл, хордлогоос урьдчилан сэргийлэх, өвчлөлд нөлөөлж байгаа хүчин зүйлийг тогтоох, тандалт, судалгаа хийх, дүнг мэдээлэх;

12.2.6. хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулах;

12.2.7. сэтгэц-зан үйлийн эмгэгт нөлөөлөх нийгэм, орчны сөрөг хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

12.2.8. нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хяналт, үнэлгээ хийх;

12.2.9. нийгмийн эрүүл мэндийн лабораторийн үйл ажиллагааг эрхлэх.

12.3. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.3.1. дархлаажуулалтыг зохион байгуулж, хэрэгжүүлэх;

12.3.2. өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулах;

12.3.3. эрт илрүүлгийг зохион байгуулж, хэрэгжүүлэх;

12.3.4. нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

12.3.5. харьяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндэд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийг тогтоох, тандалт, судалгаа хийх, үнэлэх, дүнг мэдээлэх, хянах.

12.4. Эрүүл мэндийн байгууллагын нийгмийн эрүүл мэндийн нэгж, алба, нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.4.1. тухайн эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтанд нийгмийн эрүүл мэндийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

12.4.2. тухайн эрүүл мэндийн байгууллагын төрөлжсөн чиглэлээр тандалт, судалгаа хийх;

12.4.3. тухайн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх



## 19 дүгээр зүйл. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт

19.1. Энэ хуулийн 19.2-т зааснаас бусад нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

19.2. Холбогдох хуульд заасны дагуу нийгмийн эрүүл мэндийн зарим тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын болон Эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжүүлэх бөгөөд хандив, тусламж, дэмжлэг, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлж болно.

19.3. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг эдийн засгийн ангиллаар болон тохиолдолд суурилсан, нэг иргэнээр тооцсон төлбөрийн, үр дүнд суурилсан гүйцэтгэлийн аргаар тус тус тооцож санхүүжүүлнэ.

19.4. Нийгмийн эрүүл мэндийн зарим тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлж болно.

19.5. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх, төлбөртэй тусламж, үйлчилгээний төрөл, орлого, хандив тусламжийг зарцуулах журмыг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.





## 2021-2024 оны арга хэмжээний төлөвлөгөө


1. Эрүүл идэвхтэй амьдрал
2. Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд
3. Харшилаас сэргийлэх
4. Хавдрын эсрэг
5. Орчны эрүүл мэнд

## 2022-2025 оны арга хэмжээний төлөвлөгөө

6. Элэг бүтэн Монгол
7. Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх

## 2024-2027 оны арга хэмжээний төлөвлөгөө

8. Эрүүл шүд





ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

سجس لاس سوسو لاس

Баярлалаа

